

МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
НАИРСАГ ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
Г Э Р Э Э

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Цаашид хэлэлцэн
тохирогч талууд гэж нэрлэнэ/,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард
Улсын хоорондын Найрамдал, харилцан туслалцах тухай 1960 оны
5 дугаар сарын 31-ны өдрийн Гэрээ хоёр улсын харилцааг
хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэн,

Монгол, Хятад хоёр улсын ард түмний уламжлалт найрамдлыг
бататган бэхжүүлэхийг эрмэлзэн,

Монгол, Хятад хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа,
хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэх нь хоёр улсын ард түмний
язгуур эрх ашигт нийцэн, Ази, Номхон далайн бүс нутгийн энх
тайван, тогтвортой байдал, хөгжилд тус дөхөм үзүүлнэ гэдэгт
гүнээ итгэж,

НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчмыг удирдлага болгохоо дахин
нотлож,

Үүний тулд Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах
Хятад Ард Улсын хоорондын Найрамдал, харилцан туслалцах тухай
Гэрээг шинэчлэн байгуулахаар шийдвэрлэж,

Дор дурдсан зүйлийн талаар хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш, харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Хоёрдугаар зүйл

1.Хэлэлцэн тохирогч талууд хоёр улсын парламент, засгийн газрын байгууллага, түүнчлэн олон нийтийн байгууллагын хооронд болон орон нутгийн харилцааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгоор тогтмол зөвлөлдөж байна.

2.Хэлэлцэн тохирогч талууд улс төр, эдийн засаг, худалдаа, соёл, боловсрол, шинжлэх ухаан-техник, эрүүлийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, зам харилцаа, шуудан холбоо зэрэг салбарт эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлнэ.

Гуравдугаар зүйл

1.Хэлэлцэн тохирогч талууд Ази, Номхон далайн бүс нутгийн болон харилцан сонирхсон олон улсын бусад асуудлаар шаардлагатай гэж үзвэл зөвлөлдөж байна.

2.Хэлэлцэн тохирогч талууд улс орнуудын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх болон бүс нутаг, дэлхий дахины тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх үүднээс НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд хамтран ажиллана.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэраг-улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй, нөгөө талын төрийн бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд хохирол учруулах ямар нэгэн гэрээ, хэлэлцээрийг гуравдагч оронтой байгуулахгүй, аль ч тал нөгөө талын төрийн бүрэн эрхт байдал, аюулгүй байдлыг хохироохоор өөрийн нутаг дэвсгэрийг гуравдагч улсад ашиглуулахгүй.

Тавдугаар зүйл

Энэхүү гэрээ нь хэлэлцэн тохирогч талуудаас бусад улстай байгуулсан хоёр талын болон олон талын гэрээгээр хүлээсэн үүргийг үл хөндөнө.

Зургадугаар зүйл

Энэхүү гэрээ урт удаан хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд хоёр талын тохиролцсоноор түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь энэхүү Гэрээг хүчингүй болгох тухайгаа хэлэлцэн тохирогч нөгөө талдаа нэг жилийн өмнө бичгээр мэдэгдэж болно.

Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичиг солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү Гэрээг 1994 оны 4 дүгээр сарын " 29 " өдөр Улаанбаатар хотноо монгол, хятад хэлнээ тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд хоёр эх бичвэр адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

蒙古国和中华人民共和国 友好合作关系条约

蒙古国和中华人民共和国(以下简称“缔约双方”)

鉴于一九六〇年五月三十一日缔结的蒙古人民共和国和中华人民共和国友好互助条约对发展两国关系所起的重要作用;

愿意巩固和加强蒙中两国人民之间的传统友谊;

深信进一步加强蒙中两国的睦邻友好合作关系符合两国人民的根本利益,有利于亚太地区的和平、稳定与发展;

重申遵循联合国宪章的宗旨和原则;

为此,决定修订蒙古人民共和国和中华人民共和国友好互助条约,并达成协议如下:

第 一 条

缔约双方应在互相尊重独立、主权和领土完整、互不侵犯、互不干涉内政、平等互利、和平共处原则基础上发展两国睦邻友好合作关系。

第 二 条

一、缔约双方将就发展双边关系经常进行磋商,以促进两国议会、政府机关、社会团体和地方之间关系的发展。

二、缔约双方将在政治、经济、贸易、文化、教育、科技、卫生、环保、交通、邮电等领域长期稳定地发展平等互利合作。

第 三 条

一、缔约双方将就亚太地区以及共同关心的其他国际问题根据需要进行磋商。

二、缔约双方将在联合国及其他国际组织范围内进行合作,以促进各国间合作关系的发展,推动地区及世界性紧迫问题的解决。

第 四 条

缔约双方不参加任何针对对方的军事政治同盟;不同第三国缔结任何损害另一方国家主权和安全的条约;任何

一方均不得允许第三国利用其领土损害另一方国家主权和安全。

第 五 条

本条约不涉及缔约双方根据同其他国家签订的双边和参加的多边条约所承担的义务。


第 六 条

本条约长期有效,经缔约双方同意,可对本条约进行补充或修改。缔约任何一方可提前一年书面通知缔约另一方终止本条约。

本条约须经批准,并自互换批准书之日起生效。

本条约于一九九四年四月二十九日在乌兰巴托签订,共两份,每份都用蒙文和中文写成,两种文本同等作准。

蒙古国代表



中华人民共和国代表

